

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

2024 оны 08 сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Хяналтын журмаар гомдол гаргах нь

Гомдол гаргагч: “Гэгээн хэлхээ” ХХК /РД:6341977/- Өмгөөлөгч Х.Ариунзаяа /№2302/

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Mayseven 5 давхар 503 тоот
Утас: 99880003, 99066146

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 128/ШШ2024/0196 тоот шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны 2024 оны 07 сарын 05-ны өдрийн 221/МА2024/0455 дугаартай магадлалыг дараах үндэслэлээр эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Гомдол гаргах хугацааны тухайд:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг бичгээр гарсан талаар 2024 оны 07 сарын 18-ны өдөр нэхэмжлэгчийн төлөөлөгч болон өмгөөлөгчид утсаар мэдэгдсэн бөгөөд шүүгчийн туслах ээлжийн амралтаа авах гэж байгаа шалтгаанаар 2024 оны 07 сарын 22-ны өдөр нэхэмжлэгчийн хаягаар шууданд хийсэн боловч тухайн үед нэхэмжлэгчийн оффис амарсан байсан тул магадлал гардан авах боломжгүй байгаа талаар туслахад мэдэгдсэн.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.4, Улсын дээд шүүхийн 18-р тогтоолын дагуу нэхэмжлэгч тал хяналтын журмаар гомдол гаргах хугацааг магадлал бичгээр гарсныг мэдэгдсэнээс хойш 14 хоног буюу 2024 оны 08 сарын 01-ны өдрөөс тоолох нь хуульд нийцнэ гэж үзэж хяналтын гомдлыг хүргүүлж байна.

Мөн магадлалын Тогтоох хэсгийн 3 дугаар зүйлд хяналтын журмаар гомдол гаргах хугацааг 5 хоног хэмээн бичиж техникийн алдаа гаргасан байна.

Гомдлын шаардлага:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2-д “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн”, 123.2.4-д “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” үндэслэлээр хяналтын гомдол гаргаж байгаа бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.2-д заасныг үндэслэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж өгнө үү.

Гомдлын үндэслэл:

ТЕГ-н Том татвар төлөгчийн газраас 2018.08.28-ний өдрөөс 2021.12.31-ний өдрийг дуустал хугацааны татвар ногдуулалтанд хяналт шалгалт хийж манай компанид нийт 599,995,553.58 төгрөгийн нөхөн ногдуулатын акт тавьсан.

Үндсэн хууль зөрчсөний улмаас хүчингүй болсон Ашигт малтмалын тухай хуулийн 2019.03.26-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 47.1-д “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөөт төлнө” гэж заасан байсан.

Гэтэл ТЕГ-н Том татвар төлөгчийн газрын байцаагч нар 2022 онд хяналт шалгалт хийж, нөхөн ногдуулалтын акт тавихдаа 2019 онд хүчингүй болсон хуулийг буцаан хэрэглэж манай компанийг АМНАТ төлөгч гэж тооцож акт тавьсан мөртлөө тухайн үед хэрэгжиж байсан гэх хуулийг хэрэглэхдээ борлуулалтын үнэлгээнээс бус жишиг үнээс тооцож АМНАТ ногдуулсан. Тэр үнээсээ алданги торгууль тооцсон. Өөрөөр хэлбэл хариуцагч нар 2018.08.28-ний өдрөөс 2021.12.31-ний өдрийг хүртэлх хугацааны нийт АМНАТ-ын зөрчлийг Засгийн газрын тогтоолоор баталсан зах зээлийн жишиг үнэлгээнээс АМНАТ тооцож дааж давшгүй татвар торгуулийн дарамтанд оруулж, компанийн үйл ажиллагаа зогссон.

Манай компани нөхөн ногдуулалтын актын зарим хэсгийг илт хууль бусад тооцуулах, зарим хэсгийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан бөгөөд ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад манай компани Засгийн газрын 2016.02.01-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнлэгээ, үнэлгээний үндэслэл болгох зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр”-ийн 5 дах хэсэгт “хайлуур жонш, хятадын хайлуур жоншны бүтээгдэхүүний FOB үнэ www.indmin.com” гэж заасныг хүчин хууль бусад тооцуулахаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, захиргааны хэрэг үүссэн баримтыг шүүхэд гаргаж өгсөн. Мөн тус хэрэг үүссэнтэй холбогдуулан анхан шатны шүүх дээр хэлэлцэгдэж буй хэргийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан боловч шүүх хүсэлтийг хангагүй.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хайлуур жоншийг хил хүртэл нөхцлөөр экспортлоход 1 тн нь ойролцоогоор 150 ам долларын жишиг ханштай байдаг бол ЗГ-н 81-р тогтоолын дагуу бидэнд АМНАТ тооцохдоо жишиг болгон баримтлах БНХАУ-ын хайлуур жоншны FOB-н үнэ 1 тн нь 350 ам доллар байдаг. Монгол Улсын хайлуур жонш экспортлогч нар нь жоншийг Эрээн хүртэл тээвэрлэн борлуулдаг бол БНХАУ-д мөрдөгдөж байгаа хайлуур жоншны жишиг үнэ нь МҮ-с ачигдсан хайлуур жоншны бүтээгдэхүүн Эрээн дэх гаалийн хяналтын бүсэд бууж тодорхой хугацаанд хадгалагдан импортын болон бусад холбогдох татвар хураамж төлөгдж, дараа нь 1050 км төмөр замаар Тяньжин боомтод очиж мөн зориулалтын агуулахад буун холбогдох үйл ажиллагаа хийгдэн улмаар усан онгоцны тавцанд ачигдах хүртэлх шат шатан дах зардал шингэсэн үнэ бөгөөд хийгдэх тээвэрлэлт, зарцуулагдах хугацаа, гарах зардлын хувьд ийм ялгаатай 2 зах зээлийн үнийг адилтган авч үзэж АМНАТ ногдуулж, хүү алданги торгууль тооцож байгааг хүчингүйд тооцуулахаар нэхэмжлэл гаргасан. Товчондоо Монгол Улсын Засгийн газар нь экспорт хийж буй хуулийн этгээдүүдийн борлуулалтын орлогыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, олоогүй орлогод татвар ногдуулж байгаа үйлдэл юм.

Манай компаниас Засгийн газрын 81-р тогтоолын холбогдох хэсгийг хууль бусад тооцуулахаар гаргасан нэхэмжлэлтэй хэрэг хэрхэн шийдвэрлэгдэхээс манайд ногдуулсан АМНАТ-ын үнийн дүн өөрчлөгдөх бүрэн боломжтой. Гэтэл шүүх Давж заалдах шатны шүүх дээр хэлэлцэгдэж буй хэргийн шийдвэрлэлтийг урьдчилан таамаглаж, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашны сонирхлыг үл тоон хэргийг эцэслэн шийдвэрлэсэн. Ингэхдээ нөхөн ногдуулалтын актын үнийн дүн өөрчлөгдөх боломжгүйгээр шийдвэр магадлалыг баталгаажуулсан.

Иймд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 128/ШШ2024/0196 тоот шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны 2024 оны 07 сарын 05-ны өдрийн 221/МА2024/0455 дугаартай магадлалд “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх дээр хянан хэлэлцэгдэж буй Засгийн газрын 2016.02.01-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнлэгээ, үнэлгээний үндэслэл болгох зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр-ийн 5 дах хэсэгт хайлуур жонш, хятадын хайлуур жоншны бүтээгдэхүүний FOB үнэ www.indmin.com гэж заасныг хууль бусад тооцуулах” нэхэмжлэлийн шаардлага бүхий захиргааны хэргийн шийдвэрлэлтээс шалтгаалж Маргаан бүхий нөхөн ногдуулалтын актын үнийн дүн өөрчлөгдөх боломжтой болохыг дурдаж өгнө үү.

ӨМГӨӨЛӨГЧ



Х.АРИУНЗАЯА